



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2022 оны ээлжит 05 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны ээлжит 05 дугаар хуралдаан 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдөр холимог оролцоотой (биеэр болон цахим) зохион байгуулагдав.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны ээлжит 05 дугаар хуралдаанд холбогдох бүтцийн газар, нэгжээс боловсруулсан “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2021 оны 22 дугаар хуралдааны тэмдэглэл); “Тоон телевизийн нэвтрүүлэгчийн үйлчлэх хүрээг тогтоох аргачлал”-ын төслийн тухай; “Хөдөлгөөнт холбооны 5G сүлжээний радио давтамжийн хуваарилалт ба зохицуулалт”-ын баримт бичгийн төслийн тухай; Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийг сонгох Нөхөн, дахин сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчийн бүртгэлийн тухай; Тусгай дугаарт ярианы үйлчилгээний орлого хуваарилах зарчим, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналын тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (-Нээлттэй сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай; -Улаанбаатар хотын нэр бүхий 8 ТВ үйлчилгээ эрхлэгч нарын үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүн, хэрэгжүүлэх арга хэмжээний саналын тухай; -Тусгай зөвшөөрөл олгох, нэр шилжүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай); Бусад: Интернэтийн үйлчилгээний чанарын судалгааны дүнгийн талаар танилцуулга (Хорооны 2022 оны 04 дүгээр хуралдааны тэмдэглэл) зэрэг асуудлыг тус тус авч хэлэлцэв. Тус хуралдаанаар зохицуулах хорооны 9 тогтоолыг батлан шийдвэрлэж, хуралдааны 1 тэмдэглэлээр бүтцийн нэгжийн удирдлагад хугацаатай удирдамж, чиглэлийг холбогдох газар, хэлтэст үүрэг болгов.

ХХЗХ-ноос Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14 дэх заалтыг үндэслэн 2020 оны “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам батлах тухай” 35 тоот тогтоолыг баталж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн 4825 тоот улсын бүртгэлд 2020 оны 7 дугаар сарын 03-ны өдөр бүртгүүлэн мөрдөж байна. Зохицуулах хорооны 2021 оны ээлжит 11 дүгээр хуралдааны 22 дугаар хуралдааны тэмдэглэлээр баталсан удирдамж, чиглэл болон хорооны 2022 оны ээлжит 01 дүгээр хуралдааны үеэр хорооны дарга, гишүүдээс өгсөн санал, зөвлөмжүүд, зохицуулалтын орчны өөрчлөлт, гадаад улсын туршлага, хандлага зэргийг харгалзан “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газар, ажлын хэсгээс боловсруулаад байна. Журмын төсөлд Монгол үндэсний МОН болон .MN өргөтгөл бүхий домэйн нэрийн бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах, үндэсний домэйн нэрийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах, домэйн нэр олгох үйл ажиллагааны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг сайжруулах, олон нийтэд чанартай, аюулгүй интернэтийн орчин бий болгох, домэйн нэр эзэмшигчийн болон эцсийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зэрэг зохицуулалтуудыг шинээр тусгах, Олон Улсын Интернэтийн Цахим нэр, Тоон хаягжилтын байгууллага (ICANN)-ын бодлого, зохицуулалттай уялдуулж, эрхзүйн хувьд ижил төсөөтэй улс орнуудын туршлага, уулзалт хэлэлцүүлгийн үр дүн, саналыг тус тус судлан тусгаж, баримт бичгийн нэмэлт, өөрчлөлтүүд (нийтдээ 46 зүйл заалтыг шинээр оруулсан, өөрчлөн найруулсан,

нэмэлт, өөрчлөлт оруулсан, хассан)-ийг тус тус оруулжээ. Тус хуралдаанаар “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” танилцуулга, уулзалт хэлэлцүүлэг болон цахимаар ирүүлсэн саналын товчоо, нөлөөллийн шинжилгээ, тогтоолын төсөл, хавсралт баримт бичгийн төслийг авч хэлэлцээд, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14, Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 17 тоот “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг хавсралтын хамт батлав. Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14–д заасны дагуу домэйн нэрийг бүртгэх, ашиглахтай холбогдон үүсэх харилцаа, домэйн нэр олгох үйл ажиллагааны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг сайжруулах, олон нийтэд чанартай, аюулгүй интернэтийн орчин бий болгох, домэйн нэр эзэмшигчийн ба эцсийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах харилцааг зохицуулах шинэ нөхцөл орчин бүрдэнэ гэж үзэж байна. Уг тогтоолыг хавсралтын хамт ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлтийг хянуулан бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2022 оны 01/923 албан тоотоор /2022-05-31/ хүргүүлсэн. ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4825 бүртгэлтэй 2020 оны 35 тоот тогтоолд оруулсан 2022 оны 17 тоот тогтоолыг хянаж үзээд, тогтоолоор оруулсан нэмэлтийг 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдөр ХЗДХЯ-нд бүртгэсэн болно.

Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар (2019 он), уг хуулийн 9.1.3-д заасны дагуу ХХЗХ-ноос харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг баталгаажуулах, холбогдох техникийн нөхцөл, шаардлага, норматив баримт бичиг, журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих бүрэн эрх, чиг үүргийг шинээр хэрэгжүүлж байна. Энэхүү хуулийн заалт, хорооны чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Зохицуулах хорооноос өргөн нэвтрүүлгийн технологийн дэвшил, өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн MNS 5475:2005 Хэт богино ба ультра хэт богино долгионы (VHF/UHF) газрын сүлжээний телевизийн өргөн нэвтрүүлгийн дохио/шуугианы харьцаа, цахилгаан оронгийн хүчлэгийн зөвшөөрөх хэмжээ” стандартыг шинэчилж, тоон телевизийн нэвтрүүлэгч, сүлжээний бүрхэлтийг суурин ба хөдөлгөөнт байдлаар үнэлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, процедур, хэмжилтийн зарчмыг тодорхойлсон “Тоон телевизийн нэвтрүүлэгчийн үйлчлэх хүрээг тогтоох аргачлал”-ын төслийг боловсруулсан. Хорооны 2022 оны ээлжит 05 дугаар хуралдаанд РДХЗГ-аас “Тоон телевизийн нэвтрүүлэгчийн үйлчлэх хүрээг тогтоох аргачлал”-ын төсөл, тогтоолын төсөл, нөлөөллийн шинжилгээ, биет ба цахим хэлэлцүүлэг, албан тоотоор ирүүлсэн саналын судалгааг тус тус боловсруулан хэлэлцүүлэв. Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн “Тоон телевизийн нэвтрүүлэгчийн үйлчлэх хүрээг тогтоох аргачлал”-ыг батлах тухай 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 18 тоот тогтоол, хавсралт аргачлал баримт бичгийн батлан шийдвэрлэсэн. Аргачлалыг баталснаар Өргөн нэвтрүүлгийн сүлжээний бүрхэлтийг тодорхойлоход сүлжээний төлөвлөлт хийхдээ хүлээн авалтын бүрхэлтийг хэмжүүрийн хэрэгслээр шалгаж, баталгаажуулах; хэрэв хүн амын тодорхой хувьд эсвэл газар нутгийн тодорхой хувийг хамарсан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй бол тусгай зөвшөөрлийн нөхцөлийг хангаж байгаа эсэхийг шалгах; харилцан нөлөөлөл үүссэн талаар мэдээлсэн тодорхой байрлалд хүлээн авах нөхцөлийг үнэлэх боломжийг бүрдүүлнэ. ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлтийг хянуулан бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2022 оны 01/922 албан тоотоор /2022-05-31/ хүргүүлэв.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулахаар болж 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 05 тоот тогтоолоор цаг хугацааны хуваарийг баталсан. Харилцаа холбооны зохицуулах хороо нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.9 (45.9 дэх хэсгийн 45.9.1, 45.9.2 болон 45.9.3 заалтууд), 45.11 дэх хэсгүүд, Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 287 тоот тогтоолоор батлагдсан “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам”-ын 2.11 дэх хэсэгт тус тус заасан бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлага гарсан болно. Сонгуулийн ерөнхий хорооны 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны нөхөн, дахин сонгуулийг зохион байгуулах цаг хугацааны хуваарь”-т “...Харилцаа холбооны зохицуулах хороо нь олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг хүлээн авч, бүртгэх үйл ажиллагааг 2022 оны 05-р сарын 20-ны өдрөөс өмнө зохион байгуулна...” гэж заасан. Энэхүү хуралдаанаар ХХЗХ-ны аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.9 (45.9 дэх хэсгийн 45.9.1, 45.9.2 болон 45.9.3 заалтууд), 45.11 дэх хэсгүүд, Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 287 тоот тогтоолоор батлагдсан “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам”-ын 2.11 дэх хэсэгт тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг хууль болон журмын дагуу хянан үзсэний дагуу шаардлага хангасан радио, телевизийн бүртгэлийн жагсаалтын төслийг тус тус авч хэлэлцээд, 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 06 дугаар хуралдааны “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны нөхөн сонгуулийн үеэр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн жагсаалтыг бүртгэх тухай” хуралдааны тэмдэглэлийг хавсралтын хамт батлав. Тэмдэглэлд, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн, дахин сонгуулийн үеэр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдийг энэхүү тэмдэглэлийн хавсралт ёсоор бүртгэв. Бүртгэгдсэн радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн жагсаалтыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйл, 38 болон 47 дугаар зүйлийн холбогдох хэсгүүдэд заасан үзүүлэлтүүдээр мониторинг хийх, мөн хуулийн 45.10 дах хэсэгт заасан сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий бус радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлж байгаа эсэх талаар хяналт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газар /А. Лувсан-Очир/-т үүрэг болгов.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны ээлжит 05 дугаар хуралдаанд Радио давтамж хяналт, зохицуулалтын газраас нэгтгэн боловсруулсан "Хөдөлгөөнт холбооны 5G сүлжээний радио давтамжийн хуваарилалт ба зохицуулалт"-ын баримт бичгийн төсөл болон холбогдох радио давтамжийн ашиглалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын танилцуулга, тогтоолын төсөл, баримт бичгийн талаар уулзалт хэлэлцүүлэг болон албан ёсоор ирүүлсэн саналын товчоо, нөлөөллийн шинжилгээг тус тус хэлэлцээд, хорооны хуралдааны 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн “Хорооны хуралдааны удирдамж, чиглэлийг хэрэгжүүлэх тухай” 07 дугаар тэмдэглэлээр хуралдааны үеэр хорооны дарга, нэр бүхий гишүүдээс гарсан санал зөвлөмж, удирдамж чиглэлийг тусгаж, өөрчлөлт оруулан боловсруулах, хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг Дэд дарга /Д.Сэрээдорж/, Радио давтамж хяналт, зохицуулалтын газар /З.Амгалан/-т тус тус үүрэг болгохоор тогтов. Үүнд: Хорооны нэр бүхий хорооны

гишүүдээс гаргасан санал, зөвлөмжийг "Хөдөлгөөнт холбооны 5G сүлжээний радио давтамжийн хуваарилалт ба зохицуулалт"-ын баримт бичгийн төсөлд тусган боловсруулах (Баримт бичгийн төслийн зарим заалтыг найруулах, уялдуулах 5.4, 6.2, 6.4, 6.5; шинээр 5.6 заалтыг томъёолон оруулах, хүснэгт-1 ба Хүснэгт-2-д өөрчлөлт оруулах, радио давтамжийн 2G ба 3G зурвасын мэдээлэл хүснэгтээр нэмж оруулах, 2G сүлжээг унтраах хугацааг тодорхой болгох); Үүрэн холбооны тусгай зөвшөөрлөөр радио давтамжийн 2G, ба 3G зурваст зөвшөөрөл авсан давтамжийн ашиглалтын байдалд судалгаа анализ хийх, улмаар ашиглаагүй бол буцаан авах, дахин хуваарилах асуудлыг судлах, шаардлагатай тохиолдолд холбогдох зүйл, заалтыг найруулах, заалт шинээр оруулах; Хөдөлгөөнт холбооны 5 дах үеийн технологийг нэвтрүүлэхдээ радио давтамжийн хуваарилалтын асуудлаас гадна цаашид үүрэн холбооны 5 дах үеийн сүлжээ, үйлчилгээ, үнэ тарифын зохицуулалтын арга хэмжээ, холбогдох дүрэм журмын боловсруулалтын уялдааг хангах, асуудлыг иж бүрэн цогцоор авч үзэх; Тус хорооны хуралдаанаас гарсан санал, зөвлөмжийг тусгасан баримт бичгийн төслийг эрх ашиг нь хөндөгдөж байгаа хуулийн этгээд, тусгай зөвшөөрөл эзэмшигч нарыг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулах, нэмэлт өөрчлөлттэй холбоотой саналыг албан тоотоор авах зэрэг болно.

Зохицуулах хороо нь 2014 оны "Тусгай дугаарт ярианы үйлчилгээний үнэ тариф, орлого хуваарилах зарчмыг батлах тухай" 38 тоот тогтоолыг Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.4, 9.1.6 Харилцан холболтын ерөнхий журмын 10.1.4, тус хорооны Дүрэм-ийн 3 дугаар зүйлийн 2.3, Тусгай дугаар ашигласан ярианы үйлчилгээний зохицуулалтын баримт бичгийн 6.7, 7.5 дахь заалт, үйлчилгээ эрхлэгчдийн саналыг тус тус үндэслэн баталж, өнөөг хүртэл хэрэгжүүлэн ажиллаж байна. УИХ-аас Харилцаа холбооны тухай хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 2014 оны 38 дугаар тогтоолын үндэслэл эрх зүйн зүйл, заалт өөрчлөгдсөн. Түүнчлэн 2014 оноос хойш ХХЗХ-ноос тусгай дугаарын үйлчилгээ эрхлэгчид, ТББ, цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчидтэй хамтарсан гурвалсан төлөөлөл бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж, ажлын хэсгийн дүгнэлт болон ШӨХТГ-аас дээрх тогтоолыг хүчингүй болгох саналыг албан тоотоор ирүүлсэн. Ажлын хэсгийн санал, дүгнэлтээс үзэхэд, ХХЗХ-ны 2021 оны 74 тоот тогтоолоор баталсан "Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам"-ыг шинэчлэн баталсантай холбогдуулан Тусгай дугаар ашигласан ярианы үйлчилгээний зохицуулалтын баримт бичгийн 6.7-д заасны дагуу зохицуулах хороо дээд хязгаарыг түр тогтоож болно гэсэн заалт хүчингүй болсон тул тус хорооны баталсан захиргааны хэм хэмжээний актуудыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх зорилгоор Харилцаа холбооны зохицуулах хорооны 2014 оны 38 дугаар тогтоолыг хүчингүй шаардлагатай; цаашид тусгай дугаар болон цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгч нь сүлжээнд холбогдохдоо харилцан холболтын үндсэн зарчмаар гэрээгээ байгуулан ажиллах боломжтой гэж үзсэн; Сүлжээ хооронд харилцан холболт хийх, гэрээний нөхцөл, орлого хуваарилах журмын 8.2. "Зохицуулах хороо өөрөөр тогтоогоогүй бол сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох талуудад ногдож буй төлбөрийн хэсэг бүр нь сүлжээний төрөл ба онцлогоос үл шалтгаалан өртгөө нөхсөн байна" гэсэн заалтыг баримталж ажиллах боломжтой гэж тус тус үзсэн. Хорооны 2022 он ээлжит 05 дугаар хуралдаанд энэхүү асуудлаар холбогдох бүтцийн нэгжээс боловсруулсан "Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай" танилцуулга, ажлын хэсгийн тайлан ба дүгнэлт, саналын товчоо, тогтоолын төслийг тус тус авч хэлэлцэж, Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх заалт болон үйлчилгээ эрхлэгчдийн ирүүлсэн санал, хүсэлтийг тус тус үндэслэн 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 20 тоот "Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай" тогтоолыг батлан шийдвэрлэв. Уг тогтоол батлагдсанаар тус хорооны баталсан захиргааны хэм

хэмжээний актуудыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх зорилгоор ХХЗХ-ны 2014 оны 38 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцов. Энэхүү тогтоолын 2 дугаар заалтаар, тусгай дугаарт ярианы үйлчилгээ эрхлэгчдийг Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Сүлжээ хооронд харилцан холболт хийх, гэрээний нөхцөл, орлого хуваарилах журмын 8.2. “Зохицуулах хороо өөрөөр тогтоогоогүй бол сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох талуудад ногдож буй төлбөрийн хэсэг бүр нь сүлжээний төрөл ба онцлогоос үл шалтгаалан өртгөө нөхсөн байна” гэсэн заалтыг баримталж сүлжээнд холбогдохыг зөвшөөрсөн болно. Хорооны 2022 оны 20 тоот тогтоол батлагдсанаар тусгай дугаарын үйлчилгээ үзүүлэгч нь өөрөө үнэ тарифаа тогтоох бололцоог олгох; тусгай дугаарт ярианы үйлчилгээний орлого хуваах зарчим цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчид ногдох орлогын 40 хүртэлх хувь гэсэн тогтоол цуцлагдсанаар тусгай дугаарт ярианы үйлчилгээ эрхлэгч болон цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчид орлого хуваах зарчмыг ямар нэг зохицуулалтгүй бизнесийн зарчимд шилжүүлэх; цаашид хэрэглэгчид зөвхөн тусгай дугаар ашиглахгүй мобайл платформ ашиглан бүх төрлийн лавлах үйлчилгээг сонгох боломжийг тус тус бүрдүүлнэ гэж үзэж байна. ХХЗХ-ноос уг тогтоолыг албажуулан эрх ашиг нь хөндөгдөж байгаа ШӨХТГ, тусгай дугаарын үйлчилгээ үзүүлэгч, холбогдох ТББ, цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгч нарт хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

Бусад асуудлаар, Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 04 дүгээр хуралдааны 05 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу “Үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээний ачаалал, чанарын хэмжилтийн систем” төслийн хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Интернэтийн үйлчилгээнд чанарын үнэлгээний талаар цахим судалгааг хэрэглэгчдээс авч холбогдох тайлан, санал дүгнэлтийг сонсов. Энэхүү судалгааг 2022 оны 05 дугаар сарын 02-05-ний хооронд www.ikon.mn, www.gogo.mn веб сайт болон тус хорооны фэйсбүүк хуудсаар дамжуулан олон нийтээс 2 төрлөөр авсан бөгөөд нийт давхардсан тоогоор 3423 санал асуулгыг ирүүлжээ. Тус хороонд 2021 оны хэмжээнд интернэтийн үйлчилгээтэй холбоотой 88 гомдол, үүрэн холбооны үйлчилгээтэй холбоотой 169 гомдол зэрэг үйлчилгээний чанар (ярианы чанар, интернэтийн хурд гэх мэт)-тай холбоотой 321 гомдол тус хороонд ирсэн байна. Одоогийн байдлаар эдгээр хэрэглэгчийн гомдлыг шийдвэрлэхэд гомдол гаргасан хэрэглэгчийг үйлчилгээ эрхлэгчтэй холбож өгөх арга замаар гомдлыг шийдвэрлэж байгаа бөгөөд тухайн үйлчилгээ эрхлэгчийн үйлчилгээний чанарыг хэмжих техникийн боломж тус хороонд байхгүй байна. Түүнчлэн интернэтийн сүлжээний ачааллын мэдээллийг авснаар Дараа үеийн үйлчилгээний зохицуулалтыг оновчтойгоор хэрэгжүүлэх боломжтой болно. Энэхүү зохицуулалтын хүрээнд шинэ үеийн ОТТ үйлчилгээнүүд болон сүлжээ эзэмшигч хоорондын харилцааг зохицуулах, мөн харилцаа холбооны салбарт зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зэрэг үр дүнтэй юм. Интернэтийн үйлчилгээний чанарын талаар хэрэглэгчдээс авсан судалгааны дүнгээс, үзэхэд айл өрхийн интернэтийн чанар 3.22 буюу дундаж гэсэн ерөнхий үнэлгээтэй байгаа нь интернэтийн хурд, чанарт анхаарах зайлшгүй шаардлагатай болсон байна. Мөн хэрэглэгчдийн гэрээлж авч буй интернэтийн хурдын зөрүү 2-100 Mbps хооронд байгаа нь интернэтийн хурдыг бодитоор тогтоох шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан болно. Судалгааны тайланд заасан санал, дүгнэлтийг “Үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээний ачаалал, чанарын хэмжилтийн систем” төслийг хэрэгжүүлэхэд авч үзэх, тусгах, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг холбогдох газар хэлтэст үүрэг болгов.

Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 05 дугаар хуралдааны тусгай зөвшөөрлийн тухай хэлэлцсэн асуудлын хүрээнд нээлттэй сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай; Улаанбаатар хотын нэр бүхий 8 ТВ үйлчилгээ эрхлэгч нарын үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүн, хэрэгжүүлэх арга хэмжээний саналын тухай тус тус авч хэлэлцэн шийдвэр гаргалаа. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 7.4.5 дахь заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 64 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам”, 2021 оны 71 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “2022 онд олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо” болон тус хорооноос зарласан “Орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт АРР-орон нутаг 2022/01”-ын үнэлгээний ажлын хэсгийн 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн “Нээлттэй сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” 21 тоот тогтоолыг батлав. Тогтоолд, тус хорооноос 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр зарласан Орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох “АРР-орон нутаг 2022/01” тоот нээлттэй сонгон шалгаруулалт”-д Хасүби медиа ХХК, Ар Би Эм Ти ХХК-ийг тус тус шалгарсанд тооцож, сонгон шалгаруулалтад шалгарсан тогтоолын хавсралтад заасан 2 хуулийн этгээдэд “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” болон “Радио давтамж ашиглах” тусгай зөвшөөрлийг тогтоолын хавсралтад заасан хугацаа болон хамрах хүрээнд олгохоор шийдвэрлэв.

ХХЗХ-ны Даргын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/89 тоот тушаалаар байгуулагдаж, батлагдсан удирдамжийн хүрээнд үзэгч, иргэдээс ирсэн гомдлын дагуу болон тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, дүрэм, журам, гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүй, эфирийн тасалдал ихтэй, үйл ажиллагаа доголдолтой, тасралтгүй ажиллагааны түвшин хангахгүй байгаа үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг газар дээр нь шалгаж холбогдох хууль тогтоомж, нөхцөл шаардлага, тусгай зөвшөөрлийн гэрээний хэрэгжилтийн байдалд хийсэн хэмжилт, шалгалтыг 2022 оны 04 дүгээр сарын 11-15-ны өдрүүдэд хийж гүйцэтгэж, газар дээр нь мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан байна. Шалгалтад хамрагдсан нэр бүхий 8 телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хэрэгжилт, гэрээний эрх зүй, бичиг баримтын бүрдэлт, тусгай зөвшөөрлийн хамрах хүрээ, тусгай зөвшөөрлийн төлбөр төлөлтийн байдал, техник, стандартын хэрэгжилт, мөрдөлт, аюулгүй ажиллагаа, телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага, зар сурталчилгааны зохицуулалтын журмын хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийсэн. Ажлын хэсгийн санал дүгнэлтээр шалгалтад хамрагдсан нэр бүхий хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг 3 сараар түдгэлзүүлэх, хамрах хүрээнд өөрчлөлт оруулах, шалгалтын тайлан, зөвлөмж албан тоотоор хүргүүлэх тухай асуудлыг хуралдаанаар тус тус хэлэлцээд, тусгай зөвшөөрлийн хамрах хүрээнд өөрчлөлт оруулах, 3 сараар түдгэлзүүлэх санал дүгнэлтийг дэмжиж, батлах тогтоолд оруулан батлахаар тус тус тогтов.

Хорооны 2022 оны ээлжит 06 дугаар хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай”, “Тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 5 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 5 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 22 тоот тогтоолын хавсралтаар 14 хуулийн этгээдэд 15 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.6, 5.7 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 23 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн;
- Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15 дах заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 5.1.1 дэх заалт болон 5.3 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 24 тоот тогтоолын хавсралтаар 5 хуулийн этгээдийн 10 тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 25 тоот тогтоолын хавсралтаар 4 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дах заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 26 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2022-06-14